



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ МОНГОЛ
УЛСЫН ИРГЭНД “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”
КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ**

2011 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 98

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9-ийн 1, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг”-ийн 17, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 10 хувийг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс

өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд эзэмшүүлсүгэй.

2. Хувьцаа эзэмших иргэдийн нэр, оршин суугаа хаяг болон иргэдэд үнэт цаасны данс нээх асуудалтай холбогдох мэдээллийг гэрээний үндсэн дээр "Монголын хөрөнгийн бирж" ХК, "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д шилжүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатарт даалгасугай. /ЗГ-ын 2012-1-11-ний 8-р тогтоолоор нэмэлт орсон/

3. Монгол Улсын иргэн бүрт "Эрдэнэс Тавантолгой" компанийн 536 ширхэг хувьцааг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Гандулам нарт даалгасугай.

4. Иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хувьцааг нийтэд арилжаалах ажлыг Засгийн газраас "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг хоёр дахь зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн шийдвэр гарсны дараа эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

5. "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцааг тухайн иргэнд эзэмшүүлснийг хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албадаар дамжуулан Хүний хөгжил сангийн дэвтэрт тэмдэглэгээ бүхий наалт хийх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай. 6. Иргэдийн Хүний хөгжил сангийн дэвтэрт тэмдэглэгээ бүхий наалт хийхэд шаардагдах 12.0 (арван

хоёр) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

7. Стратегийн хөрөнгө оруулагч болон оператор компанийн сонгон шалгаруулалт, түүний үр дүнд хийх ажлын явцыг харгалзан хувьцааг нийтэд санал болгох төлөвлөгөөтэй уялдуулан компанийн нэрлэсэн үнийн талаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш нарт даалгасугай.

8."Монголын хөрөнгийн бирж" ХК, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг төрийн тусгай хамгаалалтад авахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болдод үүрэг болгосугай./ЗГ-ын 2012-1-11-ний 8-р тогтоолоор нэмэлт орсон/

9. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалах бэлтгэл ажлын явцын талаар иргэдэд тодорхой мэдээлэл өгч, сургалт зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Төрийн өмчийн хороо (Д.Сугар), “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш нарт үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай.

11. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэнд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга

хэмжээний тухай Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 350 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

сайд	Монгол Улсын Ерөнхий С.БАТБОЛД
дарга	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ч.ХҮРЭЛБААТАР